

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ХЭА-2026/092/НА-СТА-ТШЗ**

Чингис хот  
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар  
Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа  
Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Аудитор: Б.Ариунаа  
Утас: 99195208 Цахим хаяг: ariunaab@audit.gov.mn

Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	11
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	12

---

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХөрөнгө	Засаг даргын нөөц хөрөнгө
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН  
ГАЗАР**

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,  
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,  
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.02.25 № 378  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХЭНТИЙ АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ  
АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Г.ГАНТӨМӨР ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх “Мал аж ахуйг хөгжүүлэх”, “Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх”, “Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн бодлого удирдлага” хөтөлбөр, 5 арга хэмжээний хүрээнд улсын төсвөөс 882,273.3 мянган төгрөгийн санхүүжилт авч 99 хувь буюу 874,274.8 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 7,998.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 102,992.1 мянган төгрөг төвлөрснөөс 95,808.8 мянган төгрөгийг зарцуулж, 7,183.3 мянган төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

### Аудитын гол асуудал

Аудитаар мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, цалингийн зардлыг аудитын чиглэл болгон чухалчлан авч үзэв.

Аудитаар нийт 112,860.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 38,200.0 мянган төгрөгийн 1 алдааг аудитын явцад санхүүгийн

тайланд залруулж, бусад хангамжийн материалын 20.1 сая төгрөгийн үлдэгдлийг тоолж, тооцоо бодож баталгаажуулаагүй, барилгын их засварын 38,200.0 мянган төгрөгийн ажлыг материал, үйлчилгээний хөлс болгон хувааж шууд худалдан авалт хийсэн, хоршоо, аж ахуйн үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтний сул орон тоонд төрийн албаны тусгай шалгалт өгөөгүй иргэнийг 2025 оны 4 дүгээр сараас ажиллуулж, сул орон тоог нөхөх талаар арга хэмжээ аваагүй 16,398.6 мянган төгрөгийн зөрчилд нийт 3 албан шаардлага хүргүүлээ.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 47 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, 94.85 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	10,625.00	0.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	10,625.00	0.00
3121	Төгрөг	10,625.00	0.00
31218	Ахмадын сангийн харилцах	10,625.00	0.00
33	АВЛАГА	9,847,786.16	10,783,584.16
335	Бусад авлага	9,847,786.16	10,783,584.16
33510	Байгууллагаас авах авлага	9,847,786.16	10,783,584.16
35	БАРАА МАТЕРИАЛ	910,677,865.26	976,223,209.66
351	Түүхий эд материал	845,989,472.96	904,323,947.36
35110	Тусгай зориулалттай материал	845,989,472.96	904,323,947.36
354	Хангамжийн материал	25,036,392.30	24,047,262.30
35410	Бичиг хэргийн материал	2,230,710.00	2,148,380.00
35420	Аж ахуйн материал	474,300.00	297,000.00
35440	Түлш, шатах тослох материал	2,270,000.00	1,540,500.00
35470	Бусад хангамжийн материал	20,061,382.30	20,061,382.30
35600	Мал амьтад	39,652,000.00	47,852,000.00
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	920,536,276.42	987,006,793.82
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	858,164,307.86	819,513,621.56
392	Биет хөрөнгө	762,153,427.70	723,722,741.56
39201	Барилга, байгууламж, орон сууц	438,827,286.26	477,027,286.26
39202	Хуримтлагдсан элэгдэл	-83,724,328.43	-95,664,964.31
39203	Авто-тээврийн хэрэгсэл	476,575,204.00	476,575,204.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-368,197,004.34	-397,158,045.52
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	324,937,900.80	345,761,590.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	-166,680,927.04	-207,455,000.75
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	72,824,716.26	79,844,316.26
39208	Хуримтлагдсан элэгдэл	-46,188,164.30	-57,127,481.90
39214	Бусад үндсэн хөрөнгө	168,538,619.64	168,538,619.64
39215	Хуримтлагдсан элэгдэл	-84,759,875.15	-96,618,782.92
39216	Дуусаагүй барилга, байгууламж	30,000,000.00	30,000,000.00
393	Биет бус хөрөнгө	96,010,880.16	95,790,880.00
39301	Програм хангамж	24,912,610.00	24,912,610.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-24,692,609.84	-24,912,610.00
39303	Бусад биет бус хөрөнгө	95,790,880.00	95,790,880.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	858,164,307.86	819,513,621.56
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,778,700,584.28	1,806,520,415.38
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	55,524,100.00
413	Өглөг	0.00	55,524,100.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	12,010,100.00
4136	Бусад өглөг	0.00	43,514,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	41,046,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0.00	2,468,000.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	55,524,100.00
51	Засгийн газрын хувь оролцоо	1,778,700,584.28	1,750,996,315.38
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,554,001,195.69	1,554,001,195.69
511001	Засгийн газрын оруулсан капитал загийн газрын сан	1,554,001,195.69	1,554,001,195.69
512	Хуримтлагдсан үр дүн	206,888,157.48	179,183,888.58
51210	Өмнөх үеийн үр дүн	-818,479,236.76	206,888,157.48
51220	Тайлант үеийн үр дүн	1,025,367,394.24	-27,704,268.90
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	17,811,231.11	17,811,231.11
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,778,700,584.28	1,750,996,315.38
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,778,700,584.28	1,806,520,415.38

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,199,536,016.00	988,552,883.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,105,181,900.00	882,273,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,105,181,900.00	882,273,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	94,354,116.00	106,279,583.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,900,000.00	96,226,930.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	75,454,116.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	10,052,653.00
12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	1,483,662,736.54	79,105,122.73
120	Нийтлэг татварын бус орлого	1,483,662,736.54	79,105,122.73
120009	Бусад орлого	-12,972,194.00	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	245,491,975.42	20,770,648.33
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	1,251,142,955.12	58,334,474.40
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,683,198,752.54	1,067,658,005.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,318,785,369.60	1,095,362,274.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,049,064,973.02	1,060,107,440.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	583,518,614.00	632,346,536.00
210101	Үндсэн цалин	360,611,743.00	382,696,761.00
210102	Нэмэгдэл	178,316,421.00	163,123,925.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,746,000.00	66,825,000.00
210104	Урамшуулал	14,844,450.00	19,700,850.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,677,831.42	81,113,988.85
210201	Тэтгэврийн даатгал	46,980,791.40	56,137,898.63
210202	Тэтгэмжийн даатгал	5,815,563.92	6,306,311.77
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,907,782.13	3,146,556.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,907,782.13	3,080,445.99
210205	Эрүүл мэндийн даатгал	16,065,911.84	12,442,776.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,665,553.00	40,453,734.01
210301	Гэрэл, цахилгаан	4,016,767.00	3,323,068.01
210302	Түлш, халаалт	31,596,836.00	34,200,766.00
210303	Цэвэр, бохир ус	3,051,950.00	2,929,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	35,931,185.00	50,114,805.00
210401	Бичиг хэрэг	4,249,860.00	11,507,730.00
210402	Тээвэр, шатахуун	17,640,000.00	15,205,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,640,100.00	2,290,075.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	540,000.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	813,225.00	21,112,000.00
210408	Бараа материал акталсны зардал	10,048,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,921,150.00	4,910,000.00
210604	Урсгал засвар	7,921,150.00	4,910,000.00
2107	Томилолт, зочны зардал	39,350,000.00	19,931,600.00
210702	Дотоод албан томилолт	39,350,000.00	19,931,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	174,237,465.66	132,773,242.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	161,788,023.66	122,659,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,648,700.00	1,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	249,420.00	314,920.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	0.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,471,450.00	8,784,950.00
210807	Газрын төлбөр	13,872.00	13,872.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	94,763,173.94	98,463,534.63
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	280,200.00	472,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	370,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	94,482,973.94	97,621,334.63
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	269,720,396.58	35,254,834.14
2132	Бусад урсгал шилжүүлэг	126,121,352.00	20,073,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,400,000.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,734,182.00	0.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	83,280,486.00	17,490,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,706,684.00	2,583,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	143,599,044.58	7,998,536.53
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	84,000,678.58	7,998,536.53
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	59,598,366.00	0.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	7,183,297.61
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	7,183,297.61
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,318,785,369.60	1,095,362,274.63
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,364,413,382.94	-27,704,268.90
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	337,311,330.00	0.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	337,311,330.00	0.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-337,311,330.00	0.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,027,102,052.94	-27,704,268.90

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,272,106,576.00</b>	<b>988,777,883.00</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,105,181,900.00	882,273,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,105,181,900.00	882,273,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>166,924,676.00</b>	<b>106,504,583.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	34,400,000.00	96,226,930.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	75,454,116.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	57,070,560.00	10,277,653.00
<b>12</b>	<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО</b>	<b>-12,972,194.00</b>	<b>0.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>-12,972,194.00</b>	<b>0.00</b>
120009	Бусад орлого	-12,972,194.00	0.00
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,259,134,382.00</b>	<b>988,777,883.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,259,134,382.00</b>	<b>988,788,508.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>989,486,985.42</b>	<b>951,336,375.86</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>583,518,614.00</b>	<b>632,346,536.00</b>
210101	Үндсэн цалин	360,614,595.00	382,706,555.00
210102	Нэмэгдэл	178,316,421.00	163,114,131.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,746,000.00	66,825,000.00
210104	Урамшуулал	14,841,598.00	19,700,850.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>74,677,831.42</b>	<b>81,113,988.85</b>
210201	Тэтгэврийн даатгал	51,415,575.40	56,137,899.63
210202	Тэтгэмжийн даатгал	5,815,563.92	6,306,310.77
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,907,782.13	3,146,556.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,907,782.13	3,080,445.99
210205	Эрүүл мэндийн даатгал	11,631,127.84	12,442,776.46
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>38,665,553.00</b>	<b>40,453,734.01</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,016,767.00	3,323,068.01
210302	Түлш, халаалт	31,596,836.00	34,200,766.00
210303	Цэвэр, бохир ус	3,051,950.00	2,929,900.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>15,410,829.00</b>	<b>15,826,375.00</b>
210401	Бичиг хэрэг	3,099,100.00	1,026,400.00
210402	Тээвэр, шатахуун	8,543,884.00	12,465,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,640,100.00	2,271,975.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	540,000.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	587,745.00	63,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>27,732,100.00</b>	<b>22,183,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,408,000.00	644,000.00
210604	Урсгал засвар	17,324,100.00	21,539,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>39,350,000.00</b>	<b>9,931,600.00</b>
210702	Дотоод албан томилолт	39,350,000.00	9,931,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>209,824,758.00</b>	<b>146,748,742.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	197,375,316.00	136,235,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,648,700.00	1,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	249,420.00	314,920.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,471,450.00	9,184,950.00
210807	Газрын төлбөр	13,872.00	13,872.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>307,300.00</b>	<b>2,732,400.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	307,300.00	2,362,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	370,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>269,647,396.58</b>	<b>37,452,132.14</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>126,048,352.00</b>	<b>21,109,500.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,400,000.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,734,182.00	0.00

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	83,280,486.00	17,490,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,633,684.00	3,619,500.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>143,599,044.58</b>	<b>7,998,536.53</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	84,000,678.58	7,998,536.53
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	59,598,366.00	0.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>0.00</b>	<b>8,344,095.61</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	8,344,095.61
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (2)</b>	<b>1,259,134,382.00</b>	<b>988,788,508.00</b>
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>0.00</b>	<b>-10,625.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>0.00</b>	<b>-10,625.00</b>
<b>14</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>10,625.00</b>	<b>10,625.00</b>
<b>15</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>10,625.00</b>	<b>0.00</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцроний нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,554,001,195.69	17,811,231.11	-818,479,236.76	0.00	753,333,190.04
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,554,001,195.69	17,811,231.11	-818,479,236.76	0.00	753,333,190.04
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
C07	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C08	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
C09	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,025,367,394.24	0.00	1,025,367,394.24
C10	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,554,001,195.69	17,811,231.11	206,888,157.48	0.00	1,778,700,584.28
C11	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,554,001,195.69	17,811,231.11	206,888,157.48	0.00	1,778,700,584.28
C12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,554,001,195.69	17,811,231.11	206,888,157.48	0.00	1,778,700,584.28
C14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C15	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
C17	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
C19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-27,704,268.90	0.00	-27,704,268.90
C20	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,554,001,195.69	17,811,231.11	179,183,888.58	0.00	1,750,996,315.38

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
12200	<b>ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	968,860,100.00	874,274,763.47
122005	Төсвөөс санхүүжих	968,860,100.00	874,274,763.47
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	968,860,100.00	874,274,763.47
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	968,860,100.00	874,274,763.47
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	939,391,200.00	853,165,263.47
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	633,527,500.00	632,346,536.00
210101	Үндсэн цалин	390,915,000.00	382,706,555.00
210102	Нэмэгдэл	177,994,500.00	163,114,131.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	44,831,900.00	66,825,000.00
210104	Урамшуулал	19,786,100.00	19,700,850.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	84,476,200.00	79,640,876.46
210201	Тэтгэврийн даатгал	57,459,200.00	54,664,787.24
210202	Тэтгэмжийн даатгал	6,752,400.00	6,306,310.77
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,375,700.00	3,146,556.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,375,700.00	3,080,445.99
210205	Эрүүл мэндийн даатгал	13,513,200.00	12,442,776.46
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	42,587,900.00	39,003,134.01
210301	Гэрэл, цахилгаан	6,579,700.00	3,323,068.01
210302	Түлш, халаалт	28,880,100.00	32,750,166.00
210303	Цэвэр, бохир ус	7,128,100.00	2,929,900.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	25,476,500.00	12,636,375.00
210401	Бичиг хэрэг	1,500,000.00	1,026,400.00
210402	Тээвэр, шатахуун	20,500,000.00	9,275,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,500,000.00	2,271,975.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	486,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	490,500.00	63,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	29,179,700.00	22,183,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,261,700.00	644,000.00
210604	Урсгал засвар	27,918,000.00	21,539,000.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	16,500,000.00	9,571,600.00
210702	Дотоод албан томилолт	16,500,000.00	9,571,600.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	105,813,700.00	57,413,742.00
210801	Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	94,210,200.00	46,900,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	185,300.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	1,600,000.00	1,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар, оношилгоо	404,400.00	314,920.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	78,800.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,200,000.00	9,184,950.00
210807	Нийтлэг үйлчилгээний төлбөр, хураамж	135,000.00	13,872.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,829,700.00	370,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,459,700.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	370,000.00	370,000.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	29,468,900.00	21,109,500.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	29,468,900.00	21,109,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	24,684,000.00	17,490,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,784,900.00	3,619,500.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</b>	968,860,100.00	874,274,763.47
4	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	10,625.00
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>102,992,010.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>102,992,010.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	95,808,712.39
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	1,473,112.39
210201	Тэтгэврийн даатгал	1,473,112.39
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	1,450,600.00
210302	Түлш, халаалт	1,450,600.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,190,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,190,000.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	360,000.00
210702	Дотоод албан томилолт	360,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	89,335,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	89,335,000.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	7,183,297.61
2133	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>7,183,297.61</b>
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	7,183,297.61
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	102,992,010.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	102,992,010.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	96,226,930.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,765,080.00

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитын явцад 38,200.0 мянган төгрөгийн 1 алдааг санхүүгийн тайланд залруулсан. Үүнд:

Залруулсан алдаа:

- Байгууллагын барилгын дээврийн засварын ажлын барилгын материалын үнэ 18,400.0 мянган төгрөг, түүний үйлчилгээний хөлс 19,800.0 мянган төгрөгийг шууд зардалд бүртгэснийг барилга байгууламжийг капиталжуулав.

Аудитаар илэрсэн 74,660.0 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлэв.

#### 3.1 Төлбөрийн акт

Байхгүй

#### 3.2 Албан шаардлага

1. Бараа материалын тайлангийн бусад хангамжийн материал дансны 20,061.4 мянган төгрөгийн үлдэгдлийг жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогоор тоолоогүй, тооцоо бодож баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана.", 70.2.2-т "түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/" гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Байгууллагын барилгын дээвэр засварын ажлыг Зүрхэн эрдэнэ ХХК-иар гүйцэтгүүлэхээр материалын үнэнд 18,400.0 мянган төгрөг, ажлын хөлсөнд 19,800.0 мянган төгрөг төлөхөөр гэрээг 2 хувааж байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно." гэсэн заалтыг зөрчсөн байна.

3. Тус байгууллага нь Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний хэлтсийн Хоршоо, аж ахуйн үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтний сул орон тоонд тусгай шалгалт өгөөгүй, нөөцөд бүртгэгдээгүй иргэнийг 2025 оны 4 дүгээр сараас түр томилон ажиллуулж байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т "Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлнэ.", 42 дугаар зүйлийн 42.1-д "Хуульд өөрөөр заагаагүй бол эрх бүхий этгээд дараахь тохиолдолд төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг төрийн жинхэнэ албан хаагчтай тохиролцсоны дагуу албан үүргийнх нь зэрэгцээ түр орлон гүйцэтгүүлж болно" гэснийг зөрчсөн байна.

**Аудитаар илэрсэн 20,061.4 мянган төгрөгийн санхүүгийн асуудлын зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.**

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулагдаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Барилгын засварын зардлыг БМ-ын тайланд зардалд бүртгэсэн.	1	38,200.0	-	-	1	38,200.0	1	38,200.0	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>38,200.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>38,200.0</b>	<b>1</b>	<b>38,200.0</b>		<b>--</b>	<b>-</b>	<b>-</b>

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хангамжийн материалыг тоолоогүй	1	20,061.4			1	20,061.4						
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>20,061.4</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>20,061.4</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

##### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
Байхгүй								
<b>Дүн</b>								
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>								
Худалдан авах ажиллагааны тухай хуулийг зөрчсөн	1	38,200.0			1	38,200.0		
Төрийн албаны тухай хуулийг зөрчсөн	1	16,398.6			1	16,398.6		
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>54,598.6</b>			<b>2</b>	<b>54,598.6</b>		
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>54,598.6</b>			<b>2</b>	<b>54,598.6</b>		



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 24

Дугаар 104-А/2370448

Чингис хот

ХЭА-2026/092/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Жилийн эцсийн тооллогоор бараа материалын тайлангийн бусад хангамжийн материал дансны 20,061,382.00 (хорин сая жаран нэгэн мянга гурван зуун наян хоёр төгрөгийн үлдэгдлийг тоолоогүй, тооцоо бодож баталгаажуулаагүй.


Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана.", 70.2.2-т "түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.2-т "хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бараа материалын үлдэгдлийг тоолж, баталгаажуулдаггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг нягтлан бодогч Н.Батсайханд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТОР



Ж.ГАНБААТАР  
Б.АРИУНАА



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 24

Дугаар 105-А/2370448

Чингис хот

ХЭА-2026/092/НА-СТА-Тшг.

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын барилгын дээвэр засварын ажлыг Зүрхэн эрдэнэ ХХК-иар гүйцэтгүүлэхээр материалын үнэнд 18,400,000.00 (арван найман сая дөрвөн зуун мянга) төгрөг, ажлын хөлсөнд 19,800,000.00 (арван есөн сая найман зуун мянган) төгрөг төлөхөөр гэрээг 2 хувааж байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулдаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг дарга Г.Гантөмөрт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТОР

Ж.ГАНБААТАР  
Б.АРИУНАА





ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 24

Дугаар 106-А2370448 Чингис хот  
ХЭА-2026/092/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймагийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллага нь Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний хэлтсийн Хоршоо, аж ахуйн үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтний сул орон тоонд тусгай шалгалт өгөөгүй, нөөцөд бүртгэгдээгүй иргэнийг 2025 оны 4 дүгээр сараас түр томилон ажиллуулж байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т "Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлнэ.", 42 дугаар зүйлийн 42.1-д "Хуульд өөрөөр заагаагүй бол эрх бүхий этгээд дараах тохиолдолд төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг төрийн жинхэнэ албан хаагчтай тохиролцсоны дагуу албан үүргийнх нь зэрэгцээ түр орлон гүйцэтгүүлж болно" гэснийг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал. бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн жинхэнэ албан хаагчийн сул орон гарсан тохиолдолд олон нийтэд мэдээлдэггүй, төрийн албаны шалгалт өгөөгүй албан хаагчаар гүйцэтгүүлдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг дарга Г.Гантөмөрт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТОР

Ж.ГАНБААТАР  
Б.АРИУНАА